

137 *Зоригтой байхад туслаач* (Үйлс 4:29)

1. Хамаг олныг аврах хүчтэй

Хаанчлалын тухай сайн мэдээг
Хүчээ дайчлан түгээж явахад
Хавчин хяхдаг хүн олон
Хэнээс ч бид айж сүрдэхгүй
Зөвхөн танд үнэнчээр зүтгэе
Хэмжээлшгүй хүчээ бидэнд хайрлаач
Залбирахад анхааран сонсооч

(ДАХИЛТ)

*Айдсаа ялан дийлэхэд туслаач
Хүсэл зориг соёрхооч
Аюул ослыг сөрөн зогсож
Хүн бүрд сайн мэдээ хүргэе
Агуу өдөр ойртох тусам
Тууштай байх хүч тэнхээ өгөөч
Айдсаа ялан дийлэхэд туслаач
Тандаа залбиръя*

2. Хүчин мөхөс биднийг санаж

Урам зоригийг бадраагаач
Хэзээ ямагт дэмжинэ гэдэгт
Үргэлж тандаа итгэдэг
Айлган сүрдүүлдэг бүхнээс
Авран хамгаалаач биднийгээ
Ачит таныхаа өмөг түшгээр
Ариун нэрийг тань тунхаглая

(Дахилт)